

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ГУЧИНГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны аравдугаар сарын 20-ны 14 цаг 10 минутад эхэлж, 16 цаг 35 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 25 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35¹ дугаар зүйлийн 35¹.1.6, Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2016 оны НСШ/46 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн:</p> <p>Буянтогтохын Нямааг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
2	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35¹ дугаар зүйлийн 35¹.1.6, Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар</p>

		<p>зүйлийн 8.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2016 оны НСШ/47 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн:</p> <p>Балдоржийн Баатарцогтыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
3	<p>Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35¹ дугаар зүйлийн 35¹.1.8, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2016 оны НСШ/49 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн:</p> <p>Данзангийн Соёлчхүүг Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Орхон аймгийн Засаг дарга Д.Батлутад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
4	<p>Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн</p>	

	<p>нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35¹ дугаар зүйлийн 35¹.1.8, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2016 оны НСШ/48 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн:</p> <p>Сэдэдийн Бат-Эрдэнийг Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Батсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
5	<p>Үндэсний хөгжлийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35¹ дугаар зүйлийн 35¹.1.6, Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2016 оны НСШ/38 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн:</p>

		<p>Банзрагчийн Баярсайханыг Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
6	<p>Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын, Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд тус тус томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус үндэслэж төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 27 дугаар дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар 20-ны өдрийн хуралдаанаас:</p> <p>Жансэдийн Гантөмөрийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус үндэслэж төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 28 дугаар</p>

		<p>дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар 20-ны өдрийн хуралдаанаас:</p> <p>Рэнцэндоржийн Мэргэнийг Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
7	Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай. Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,</p> <p>Гишүүд: -</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаан удирдлагын хэлтсийн дарга, - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,

		<ul style="list-style-type: none"> - Аймгийн Шүүхийн Тамгын хэлтсийн дарга - Аймгийн Цагдаагийн газрын дарга, - Аймгийн Ерөнхий аудитор, - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга, <p>Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн. <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 19, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 19 дэх хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 29, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 209 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--	---

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**

